



ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЧАНАРЫН ДОТООД ХЯНАЛТ

Э.ТУНГАЛАГ
/ЗӨСҮТ-ЧХУДАА-НЫ ДАРГА/

Агуулга:

- Эрх зүйн орчин
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний аюулгүй байдал
- Чанарын хяналт, байгууллагын үйл ажиллагааны дотоод хяналт 2-ын ялгаа
- Магадлангийн шалгуур үзүүлэлт /Дээрхи сэдэвтэй холбоотой/

Нэг. Эрх зүйн орчин

- “Чанарын албаны дүрэм батлах тухай” 2012 оны Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 06/25 дугаар тушаал
- “Удирдамж, загвар батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2012 оны 274 дугаар тушаал /ИМУ, санамсаргүй алдаа зөрчлийг бүртгэж мэдээлэх/
- “Эрүүл мэндийн байгууллагын эрсдэлийн удирдлага, эмнэл зүйн эрсдэлийг үнэлэх, бууруулах төлөвлөгөө боловсруулах аргачлал” батлах тухай ЭМС-ын 2012 оны 375 дугаар тушаал/6-р хавсралт
- “Чанарын хөтөлбөрийн загварыг батлах тухай” ЭМСын 2013 оны 437 дугаар тушаал (Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд)
- “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны аргачлал батлах тухай” ЭМС-ын 2013 оны 13 дугаар тушаал
- “Мэс заслын тусламж үйлчилгээнд хяналтын хуудас нэвтрүүлэх тухай “ ЭМС-ын 2013 оны 177 дугаар тушаал
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах стратеги /2018-2022 он/

Хоёр: Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа

Тусламж үйлчилгээний чанарын тасралтгүй сайжруулалт:

- Чанар сайжруулах нэгжийн бүтэц /чанарын алба/баг/
- Чанарын дотоодын хяналт /тойрон үзлэг, ажиглах, хяналтын хуудас/
- Санамсаргүй алдаа, зөрчлийг бүртгэх, мэдээлэх
- Эрсдэлийн үнэлгээ, Эрсдэлийн менежмент
- Хяналтын хуудас ашиглах /ДЭМБ, ЭМЯ-аас гаргасан хяналтын хуудас/
- Аюулгүй үйл ажиллагааг хэрэгжүүлэх /дүрэм, журам/
- Бусад

Шалгуур үзүүлэлт.

Тогтмол үйл ажиллагаатай чанарын алба, багтай, төлөвлөгөөтэй байх

- Чанарын албаны дүрэм батлах тухай” 2012 оны Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 06/25 дугаар тушаалын 1.4-д зааснаар тухайн байгууллагын бүтэц, зохион байгуулалт зэргээс хамаарч, чанарын алба/багийг 3-5, 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулна.
- Дүрмийн 1.6-д Чанарын алба нь тасаг, нэгжүүдэд чанарын багийг байгуулан ажиллана.

Чанарын албаны бүрэлдэхүүн:

■ Орон тооны гишүүд:

- 1.Эмнэлгийн чанарын албаны дарга
- 2.Чанарын менежер
- 3.Лавлагаа үйлчилгээний ажилтан

■ Орон тооны бус гишүүд:

- 1.Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга/нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга
- 2.Сувилахуйн албаны дарга
- 3.Эмгэг судлаач эмч
- 4.Тархвар судлаач эмч
- 5.Мэдээллийн мэргэжилтэн статистикч их эмч
- 6.Эм зүйч
- 7.Эрүүл мэндийн даатгалын эмч

- Чанарын алба/багийн ажиллах журамд гишүүдийн ажил үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг тусгана.
- Чанарын алба/баг нь байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, ЧХХ-ийг хэрэгжүүлэхтэй уялдсан үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулж, хэрэгжилт, үр дүнг тооцно.
- Чанарын алба нь “Удирдамж, загвар батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2012 оны 274 тоот тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Чанарын албаны үйл ажиллагааны үлгэрчилсэн төлөвлөгөөний загвар”-ын дагуу жил бүрийн төлөвлөгөөг боловсруулж, баталгаажуулан, хэрэгжүүлж ажиллана.

- Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага нь “Тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2013 оны 437 тоот тушаалаар батлагдсан загвараар хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ. Хөтөлбөрт тусгасан үйл ажиллагаануудыг байгууллагын болон чанарын албаны жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллана.
- Төлөвлөгөө, хөтөлбөрт жилд 2 удаа дотоодын хяналт хяналт шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт гарган ажиллана.

Шалгуур үзүүлэлт: Байгууллага нь чанарын үзүүлэлтийг баталж, мөрдүүлсэн, түүнд нь ахиц гарсан байх

- Өөрийн үзүүлж буй тусламж үйлчилгээний хүрээнд эрүүл мэндийн статистик болон үйл ажиллагааны үзүүлэлтэд үндэслэн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан баталж, гүйцэтгэлд жилд 2 удаа дүн шинжилгээ хийж, түүний мөрөөр арга хэмжээ авч ажиллана.
- Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв нь ЭМЯ-наас баталсан жилийн ажлыг үнэлэх үзүүлэлтүүдтэй уялдуулан чанарын шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байна. /нийтлэг, өвөрмөц/

Шалгуур үзүүлэлт: Эрүүл мэндийн ажилтнуудыг жил бүр чанарын сургалтад хамруулсан байх

- Байгууллага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийгэмлэг, холбоод болон бусад мэргэжлийн байгууллагатай хамтран тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр жилд 2-оос доошгүй сургалт зохион байгуулж, бүх ажилтнуудыг хамруулсан байна.
- Сургалтын удирдамж хөтөлбөрийг баталж, тайлан, сургалтын үнэлгээ, мэдлэгийн ахиц, оролцогчдын бүртгэл, гэрчилгээтэй байхаар баталгаажилт хийгдсэн байна.

Шалгуур үзүүлэлт: Чанар сайжруулах дэвшилтэт аргуудыг нэвтрүүлсэн, үр дүнг тооцсон байх

Тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах үр дүнтэй аргуудыг тусламж үйлчилгээндээ ашиглах нь байгууллагын үйл ажиллагаан дах зөрчил, дутагдлыг эрт илрүүлэх, арилгахад тустай үйл ажиллагаа болдог. Иймд байгууллага нь тусламж үйлчилгээний чанар сайжруулах дараах аргуудаас ашиглаж үр дүнг тооцож ажиллана.

- Мэдээлэл цуглуулах
- Асуумж судалгаа
- Чанарын аудит
- Хяналтын хуудас
- Фокус ярилцлага
- Тойрон үзлэг
- Ижил мэргэжилтний үзлэг
- COPE
- “5C” арга
- Кайзен санал
- Бусад байгууллагын сайн туршлага гэх мэт.

Шалгуур үзүүлэлт: Байгууллага нь үйлчлүүлэгч/ажилтан бүрээс сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлдэг байх.

- Байгууллага нь өөрийн ажилтнуудаас 6 сар тутамд үйлчлүүлэгчээс улирал тутамд чанарын удирдлагын талаар сэтгэл ханамжийн судалгаа аван дүн шинжилгээ хийж, түүний мөрөөр ажил зохион байгуулж, тогтмол эргэн мэдээлнэ.
- “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны аргачлал батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2014 оны 13 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Эмч, эмнэлгийн ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгаа”-ны асуумжид өгөгдсөн загварыг ашиглан өөрийн байгууллагын онцлогт тохируулан асуумжийг боловсруулна.
- Судалгааны үр дүнг шийдвэр гаралт, төлөвлөлтөд ашиглаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар ажилтнуудад тогтмол мэдээлж ажиллана.

Шалгуур үзүүлэлт: Үйлчлүүлэгчдийн санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг байх.

- Байгууллага нь ажилтнууд ба үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, өргөдөл гомдлыг нээлттэй авахаар хайрцаг байрлуулах, утас ажиллуулах, уулзалтын хуваарь гаргаж биечлэн уулзах, хариуцсан ажилтан томилон ажиллуулах, байгууллагын вэб хуудсаар асуулт, санал хүсэлтэд хариулах зэрэг ажлыг зохион байгуулна.
- Санал, хүсэлтийг авах хайрцгийг хүлээлгийн танхимууд, лавлагаа мэдээллийн хэсэгт байрлуулах ба өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэн эргэн мэдээлж, бүртгэл хөтөлсөн байна. Мэдээллүүдийг сар, улирал, хагас, бүтэн жилээр нэгтгэж, дүгнэлт хийж ажиллана.

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал ба эмнэлгийн алдаа, зөрчил

Аюулгүй байдал алдагдсан нөхцөлд эмнэлгийн алдаа гарах магадлал маш өндөр байдаг.

- Эмийн гаж нөлөө, эмийн хэрэглээ ба шархны халдвартай холбоотой
- Ятрогенный өвчин - эмнэлгийн ажилтаны үйлдэлтэй холбоотой үүссэн эмгэг, ЭТҮХХ, хэвтрийн цоорол, г.м.
- Эмнэлэгт хэвтэх хугацаанд үүссэн эмнэлгийн бус осол (унаж гэмтэх...)
- Үйлчлүүлэгч амиа хорлох (ажилтаны зүгээс хараа хяналт дутсан)
- Үйлчлүүлэгчтэй зохисгүй харьцах (дайрч доромжлох)
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн эвдрэл, ашиглалтын алдаа
- Бусад

Шалгуур үзүүлэлт: Алдаа зөрчлийг бүртгэж, мэдээлдэг, хариу арга хэмжээ авдаг байх

- Эрүүл мэндийн сайдын “Удирдамж, загвар батлах тухай” 2012 оны 274 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний алдаа, зөрчлийг бүртгэх, мэдээлэх заавар”-ыг ашиглан Алдаа зөрчлийн сан ажиллуулах, алдаа зөрчлийг бүртгэж, мэдээлэх журам боловсруулах
- Байгууллага нь ДЭМБ-ын тодорхойлсон ангиллын дагуу үзүүлж буй тусламж үйлчилгээнд гарсан алдаа, зөрчлийг зааврын 4.2-т заасан үйл явцын дагуу мэдээллэх хуудсыг ашиглан бүртгэж, мэдээлж, тайлагнана.

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал ба эрсдэл

Ирээдүйд болох магадлалтай, гэнэтийн, огт хүсээгүй, тааламжгүй хохирол авч ирдэг үйл явдлыг Эрсдэл гэнэ.

Жишээ: Үйл ажиллагаатай холбоотой үүсэх эрсдэл:

- Эрүүл ахуй халдвар хамгаалал,
- эмчилгээ, оношилгооны технологи
- сувилахуйн тусламж үйлчилгээ,
- эм, эмнэлгийн хэрэгсэл,
- тоног төхөөрөмжтэй холбоотой,
- Санхүү, барилга байгууламж,
- хөдөлмөр хамгаалал, хангамж
- аюулгүй байдалтай холбоотой гарах эрсдэл г.м

Аюулгүй байдал ба эрсдэлийн удирдлага

Байгууллагын эрсдэлийн удирдлага гэдэг нь:

- тухайн байгууллагад тохиолдож болох аюул ослыг тодорхойлж тооцоолох, аюул осолд хүргэж болох эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх,
- нэгэнт аюул осол, эрсдэл нүүрлэсэн тохиолдолд түүнийг хохирол багатайгаар даван туулах, эрсдэлийг бууруулах,
- ирээдүйд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлээс ангид байх цогц үйл ажиллагаа юм.

Эрсдэлийн удирдлага нь эмнэлгийн байгууллагад үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгч нарт хохирол үүсэх магадлалыг багасгах тогтолцоо юм.

Шалгуурүзүүлэлт:

Байгууллага нь аюулгүй байдал, эрсдлийн багтай, үнэлгээг тогтмол хийж эрсдэлээс сэргийлэх, бууруулах арга хэмжээ авч ажиллах

- Эрүүл мэндийн сайдын 2012 оны 375 тоот тушаалын 6-р хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын эрсдэлийн удирдлага, эмнэлзүйн эрсдлийг үнэлэх, бууруулах төлөвлөгөө боловсруулах аргачлал”-д заасан дагуу байгууллага нь эрсдлийн удирдлагын багтай /хариуцсан ажилтан/ ажиллана.
- Багт /ажилтан/ удирдах ажилтнаас гадна холбогдох эмч, мэргэжилтнүүд, хөндлөнгийн байгууллагын шинжээч байх бөгөөд шаардлагатай тохиолдолд бусад ажилчидыг татан оролцуулна.
- Багийн гишүүн бүрийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхойлж баталгаажуулсан журамтай, эрсдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан ажиллана. Эрсдэлийн удирдлагыг хянах үүргийг байгууллагын дотоод аудитын нэгж/ ажилтанд хариуцуулж болно.

Шалгуур үзүүлэлт: Аюулгүй байдалтай холбоотой алдаанаас хохирсон ажилтан, үйлчлүүлэгч нарт дэмжлэг үзүүлэх журам боловсруулан мөрдөх

Байгууллагын үзүүлж буй тусламж үйлчилгээний аюулгүй байдал зөрчигдсөн, үйлчилгээ үзүүлэгчийн гаргасан алдаа, зөрчлийн улмаас болон хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагаа зөрчигдсөний улмаас үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учлуулсан тохиолдолд хохирсон ажилтан болон үйлчлүүлэгчдэд дэмжлэг үзүүлэх журам боловсруулан мөрдөж ажиллана.

Гурав.Тусламж үйлчилгээний чанарын дотоод хяналт

*“Хэрэв та хэмжиж чадахгүй бол
сайжруулж чадахгүй”*

Петер Друкер

Чанарын хяналт

Аливаа байгууллага чанарын мониторингийн /хяналтын/ тогтолцоотой байж л амжилтанд хүрнэ.

Чанарын хяналт шинжилгээний зорилго нь чанарын өнөөгийн түвшин ба хүлээж буй түвшин 2-н хоорондох зөрөөг хэмждэг.

Чанарын хяналт шинжилгээ хийнэ гэдэг нь тухайн үйл явдалтай холбоотой үзүүлэлтийн мэдээллийг цуглуулж, түүнд дүн шинжилгээ хийхэд оршино.

Чанарын хяналт-/мониторинг/

Эрүүл мэндийн байгууллага нь дараах асуудалд зайлшгүй мониторинг хийх ёстой. Үүнд:

- Хүлээн авах тасгийн хүлээлт
- Төсөв хөрөнгийн зарцуулалт
- Өвчлөл, эмнэлгийн дотоод халдвар
- Эмийн хангамж
- Тоног төхөөрөмжийн ашиглалт
- Үйлчилгээний байдал
- Хоолны амт чанар
- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж г.м

Эдгээр асуудлуудын талаар байнгын мэдээлэлтэй байж, түүндээ дүн шинжилгээ хийж, үйл ажиллагаагаа сайжруулж байвал тусламж үйлчилгээний чанар сайжирна.

Чанарын дотоод хяналт хийх аргууд

- Хяналтын хуудас боловсруулан ашиглах
- Ажиглах – үйлдлийг хийж байхад стандарт дагуу байгаа эсэх
- Хийж гүйцэтгэсэн үед баримтжуулалт

Хяналтыг хэн хийх вэ

Хариуцсан чиглэлээр:

- Чанарын алба
- Чанарын орон тооны бус гишүүд
- Тасгийн эрхлэгч
- Их эмч нар
- Сувилагч тусгай мэргэжилтэн
- Асрагч /үйлчлэгч/

Чанарын хяналтын чиглэл



Хяналтын хуудас ашиглах

* Хяналтын хуудас нь үйл явцын мөн чанар, учир шалтгааны холбооны талаар тоон мэдээллийг цуглуулахаар тусгайлан бэлтгэсэн чиглэл бүхий маягт

*Хяналтын хуудсыг батлагдсан стандарт, удирдамж ашиглан боловсруулж болно.

*Алдаанаас сэргийлэхийн тулд үйл явцыг хянах энгийн арга

* Хяналтын хуудсаар үйл явцыг нилээн тодорхой хугацаанд судалдаг, харьцуулан үр дүнг үнэлж болно

ГАР УГААЛТЫГ ҮНЭЛЭХ ХЯНАЛТЫН ХУУДАС

| № | Шалгуур үзүүлэлт | Үнэлгээ /тийм бол 2, үгүй бол 0/ | Үнэлгээнд хамрагдсан мэргэжилтнүүд | | | | | | |
|----|---|--|------------------------------------|--|--|--|--|--|--|
| | | | | | | | | | |
| 1. | Гар угаах нөхцөлөө бүрдүүлсэн байдал | Тийм | | | | | | | |
| | | Үгүй | | | | | | | |
| 2. | Гараа норгосны дараа хангалттай хэмжээгээр саван авна | Тийм | | | | | | | |
| | | Үгүй | | | | | | | |
| 3. | Саванг хөөсөртөл алгаа хооронд нь сайн үрнэ. Нэг гарын алгаар нөгөө гарын алгаа, ар талыг, хурууг, 2 гарын хурууны завсарыг үрж угаана. | Тийм | | | | | | | |
| | | Үгүй | | | | | | | |
| 4. | Хурууг үеэр нугалж алган дотроо хурууг сайн үрнэ. Хоёр гарын хурууны үзүүрийг угаана. | Тийм | | | | | | | |
| | | Үгүй | | | | | | | |
| 5. | Эрхий хуруу, хуруунуудыг гарын алган дотроо эргэлдүүлэх хөдөлгөөнөөр сайн үрнэ. | Тийм | | | | | | | |
| | | Үгүй | | | | | | | |
| 6. | Гарын шууг нөгөө гараараа тойруулан барьж мушгих маягаар угаана. | Тийм | | | | | | | |
| | | Үгүй | | | | | | | |
| 7. | Гараа усаар зайлж, нэг удаагийн цаасан алчуураар арчина. Крантыг цаасан алчуураар жийрэглэж хаана. | Тийм | | | | | | | |
| | | Үгүй | | | | | | | |
| 8. | Дээрхи үйлдлийг 4-5 удаа 40-60 секундын туршид угаана. | Тийм | | | | | | | |
| | | Үгүй | | | | | | | |

Тайлбар 0,2 гэсэн оноогоор үнэлнэ. /16 оноо авсан бол хангалттай, 12-оос доош оноо авсан бол хангалтгүй гэж үнэлнэ/

Үнэлгээ хийсэн:

Үнэлгээг зөвшөөрсөн:

Хяналт хийсний дараа

- * Ямар түвшинд байгаа
- * Юун дээр яагаад алдав
- * Үүний шалтгаан юу вэ
- * Яаж сайжруулах вэ
- * Ямар ур чадвар дутагдаж байгаа
- * Ямар арга хэмжээ авах вэ
- * Хяналт хийсэн баримтжуулалт
- * Гарсан алдааг бүлэглэх
- * Бүлэг бүр дээр юу хийхийг тодорхой заах

БАРИМТЖУУЛАЛТ

/ИЛТГЭХ ХУУДАС №-загвар/

.....оны.....сарын.....өдөр батлуулсан..... Удирдамжийн дагуу.....
(алба, тасгийн).....хүний бүрэлдэхүүнтэйгээр.....хоногийн хугацаатай.....(алба тасагт) хяналт хийлээ.

- ❖ Одоогийн нөхцөл байдал.....
- ❖ Сайн тал:.....
- ❖ Дутагдалтай тал:
- ❖ Дүгнэлт:...
- ❖ Газар дээр нь авсан арга хэмжээ:.....
- ❖ Цаашид авах арга хэмжээ:.....
- ❖ Хяналт хийсэн хүний нэр: 1. / /
2. / /
3. / /
- ❖ Танилцсан:
..... албаны дарга / /
..... тасгийн эрхлэгч / /

Тайлан, нэгтгэл, дүн шинжилгээ

| | Чанарын хяналт | Тоон үзүүлэлт | Үндсэн үзүүлэлт |
|----|---|-------------------------|--|
| 6 | Нийт дотоодын хяналт | 1201 | Өдөр тутам |
| | Үүнээс: <i>илэрсэн зөрчил</i> | 713 | |
| 7 | Сахилга хариуцлага, ёс зүй харилцааны | 8 | -ажил тасласан |
| 8 | АШБМ-ын хөтлөлт | 239 | мэдээ өгөлт -эрүүл мэндийн судалгаа -карт хөтлөлт -түүх хөтлөлт |
| 9 | ЭШХалдварын бүртгэл мэдээлэл | 363 | -эрсдлийн бүртгэл -хог хаягдал |
| 10 | Түгээмэл үйлдэл, гардан үйлдлийн стандарт технологийн зөрчил - эмчилгээ оношлогоо - Асаргаа сувилгаа - халдвар хамгаалал - Аж ахуй, үйлчилгээ | 10 20 4 8 2 | |

Байгууллагын дотоод хяналт


Шалгуур үзүүлэлт: Дотоод хяналтын нэгж, ажилтанг ажиллуулж, хяналтыг тогтмолжуулсан байх

- МУ-ын ЗГ-ын 2011 оны 311-р тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу зохион байгуулалтыг хийж, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- Дотоод хяналтын төлөвлөгөө, хяналтын график батлан хэрэгжүүлж гүйцэтгэлийн үр дүнг тооцсон байна.
- Дотоод хяналтын нэгж, ажилтан нь байгууллагын өдөр тутмын дотоод үйл ажиллагаа, хүний нөөцийн ажлын гүйцэтгэл, цаг ашиглалт, ёс зүй зэрэгт байнгын хяналт тавихаас гадна чанарын алба, халдварын сэргийлэлт, хяналтын алба/ багтай хамтран хяналтыг явуулж болно

Чанарын хяналт, байгууллагын дотоод хяналтын ялгаа

Чанарын хяналт-
Өдөр тутмын эмчилгээ
оношилгоо болон
сувилахуйн стандарт,
удирдамж, гардан
технологи үйлдлийн
хэрэгжилтэд дүн
шинжилгээ хийх

Байгууллагын дотоод хяналт-Байгууллагын өдөр тутмын **дотоод үйл ажиллагаа** /төлөвлөлт, дотоод журам, тушаалын хэрэгжилт, баг, хороо, комиссуудын ажлын гүйцэтгэл, санхүү гэх мэт/-нд хяналт хийдэг



**Анхаарал
хандуулсанд
баярлалаа**